ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ХЭА-2022/06/НА-СТА-ТШ3**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Чингис хот<br>2022 он | Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар<br>Утас: 70562112<br><br>Аудитын менежер: Д.Оюунтуяа<br>Утас: 99775390<br><br>Аудитор: Б.Ариунаа<br>Утас: 93032714<br><br>Цахим хаяг: www.audit.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга


1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ ..... 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 9
3. Аудитын тайлан ..... 10
3.1 Ерөнхий зүйл ..... 10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ..... 10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 10
3.4 Материаллаг байдал ..... 11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 12
3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 13
3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 13
3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 13
3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 13
4. Аудитын илрүүлэлт ..... 13
4.1. Залруулсан алдаа ..... 13
4.2. Албан шаардлага ..... 13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ..... 14

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 26

танай _____________ -ны № _______________ -т

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА, ЦАГДААГИЙН ХУРАНДАА Д.БАТХҮҮ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийч олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

023030031

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **439,982,223.82** | **402,519,046.15** |
| **33** | **АВЛАГА** | 81,843,875.00 | 72,824,402.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,277,475.00 | 1,406,355.00 |
| **335** | **Бусад авлага** | 79,566,400.00 | 71,418,047.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 79,566,400.00 | 71,418,047.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 4,930,750.50 | 4,623,152.50 |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 4,930,750.50 | 4,623,152.50 |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 4,930,750.50 | 4,623,152.50 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 353,207,598.32 | 325,071,491.65 |
| **351** | **Түүхий эд материал** | 123,303,127.45 | 124,372,431.95 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 122,890,807.45 | 121,888,904.95 |
| 35130 | Эм боох материал | 412,320.00 | 2,483,527.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 141,093,356.87 | 110,291,513.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 20,056,602.00 | 6,513,133.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 51,967,681.40 | 33,562,421.40 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,210,000.00 | 3,210,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 12,852,559.86 | 7,758,741.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 12,307,500.00 | 18,371,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 1,102,093.00 | 514,750.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 39,596,920.61 | 40,360,868.30 |
| 35600 | Мал амьтад | 88,811,114.00 | 90,407,546.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **6,625,652,776.68** | **6,384,661,451.48** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 6,625,652,776.68 | 6,384,661,451.48 |
| **392** | **Биет хөрөнгө** | 5,682,233,776.68 | 5,441,242,451.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 5,247,278,075.92 | 5,247,278,075.92 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (751,697,722.53) | (904,750,971.21) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 372,814,034.94 | 484,586,585.08 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (194,208,747.61) | (250,893,420.04) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 1,151,738,567.61 | 1,267,115,442.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (490,512,222.61) | (712,265,318.68) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 110,947,287.18 | 110,947,287.18 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (42,834,391.80) | (54,874,328.58) |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 56,538,109.00 | 56,538,109.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 250,050,183.00 | 250,050,183.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (27,879,396.42) | (52,489,192.98) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 943,419,000.00 | 943,419,000.00 |
| 39301 | Програм хангамж | 900,000.00 | 900,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (900,000.00) | (900,000.00) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **7,065,635,000.50** | **6,787,180,497.63** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **72,829,300.00** | **58,991,034.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 72,829,300.00 | 58,991,034.00 |
| **413** | **Өглөг** | 72,829,300.00 | 58,991,034.00 |
| **4136** | **Бусад өглөг** | 72,829,300.00 | 58,991,034.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 72,829,300.00 | 58,991,034.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **6,992,805,700.50** | **6,728,189,463.63** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 6,992,805,700.50 | 6,728,189,463.63 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 2,722,692,062.39 | 2,722,692,062.39 |
| 51101 | Өмч: - төрийн | 2,722,692,062.39 | 2,722,692,062.39 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 2,625,740,157.39 | 2,361,123,920.52 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,625,740,157.39 | 2,625,740,157.39 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (264,616,236.87) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,644,373,480.72 | 1,644,373,480.72 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **7,065,635,000.50** | **6,787,180,497.63** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,450,882,424.40** | **3,912,308,912.32** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **255,981,904.40** | **309,003,276.32** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 255,981,904.40 | 309,003,276.32 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 115,849,829.23 | 114,426,223.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 82,585,050.23 | 81,901,563.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,040,000.00 | 2,100,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 31,224,779.00 | 30,424,660.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 101,905,832.17 | 162,015,925.32 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 38,226,243.00 | 32,561,128.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,194,900,520.00** | **3,603,305,636.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсөвөс** | 3,098,807,300.00 | 3,319,770,700.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,098,807,300.00 | 3,319,770,700.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **96,093,220.00** | **283,534,936.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 22,255,376.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 96,093,220.00 | 261,279,560.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,866,212,688.71** | **4,176,925,149.19** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,866,212,688.71** | **4,176,925,149.19** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,855,372,865.71** | **4,155,709,740.19** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,649,048,655.00** | **2,840,520,494.00** |
| 210101 | Үндсэн цалин | 1,655,708,529.00 | 1,593,830,932.00 |
| 210102 | Нэмэгдэл | 960,990,326.00 | 1,215,140,462.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 32,349,800.00 | 31,549,100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **65,955,635.00** | **69,526,588.29** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,000,586.00 | 9,831,853.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,052,690.00 | 1,008,275.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 827,718.00 | 947,224.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 275,229.00 | 217,277.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 53,799,412.00 | 57,521,959.29 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **173,276,120.22** | **172,902,857.85** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 66,410,190.23 | 74,678,523.00 |
| 210302 | Түлш, халаалт | 78,990,183.99 | 82,869,795.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 27,875,746.00 | 15,354,539.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **220,956,958.70** | **303,670,779.32** |
| 210401 | Бичиг хэрэг | 30,616,089.00 | 24,769,523.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 154,885,039.00 | 196,667,842.01 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 20,963,932.00 | 21,982,540.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 210,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 767,960.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,106,080.00 | 8,984,849.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 10,407,858.70 | 50,486,025.31 |
| **2105** | **Нормативт зардал** | **66,667,976.00** | **149,556,639.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,224,460.00 | 2,762,950.00 |
| 210502 | Хоол, хүнс | 61,742,301.00 | 146,793,689.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,701,215.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **79,249,231.00** | **87,584,179.50** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 5,039,622.00 | 16,102,767.50 |
| 210604 | Урсгал засвар | 74,209,609.00 | 71,481,412.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **20,094,900.00** | **27,104,924.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,094,900.00 | 27,104,924.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **10,099,984.00** | **6,477,381.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 7,499,700.00 | 3,816,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,505,000.00 | 1,505,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 451,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 407,000.00 | 407,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 237,284.00 | 299,081.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **570,023,405.79** | **491,406,956.52** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,444,302.00 | 22,298,206.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,091,988.05 | 968,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 552,487,115.74 | 468,140,750.52 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **10,839,823.00** | **28,174,349.71** |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | **1,118,902.00** | **2,197,263.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **9,720,921.00** | **18,948,146.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,500.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,220,421.00 | 18,448,146.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | **70,000.00** |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | **6,958,940.71** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,958,940.71 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(415,330,264.31)** | **(264,616,236.87)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(415,330,264.31)** | **(264,616,236.87)** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,284,322,206.23** | **3,693,618,799.00** |
| **12** | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 83,921,686.23 | 82,313,163.00 |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **83,921,686.23** | **82,313,163.00** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 83,921,686.23 | 82,313,163.00 |
| 1200041 | **Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих** | 83,571,686.23 | 82,313,163.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 350,000.00 | - |
| **13** | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,200,400,520.00 | 3,611,305,636.00 |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **3,098,807,300.00** | **3,319,770,700.00** |
| 131001 | **Урсгал үйл ажиллагааны санхүүжилт** | 3,098,807,300.00 | 3,319,770,700.00 |
| **1311** | Нэмэлт санхүүжилтийн орлого | 101,593,220.00 | 291,534,936.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 22,255,376.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 101,593,220.00 | 269,279,560.00 |
| **2** | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,281,232,206.23 | 3,628,485,299.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,281,232,206.23** | **3,628,485,299.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,275,413,304.23** | **3,621,878,036.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **2,646,553,700.00** | **2,843,736,900.00** |
| 210101 | **Үндсэн цалин** | 1,655,675,900.00 | 1,603,401,000.00 |
| 210102 | Нэмэгдэл | 958,528,000.00 | 1,208,786,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 32,349,800.00 | 31,549,100.00 |
| **2102** | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 67,516,300.00 | 69,725,200.00 |
| 210201 | **Тэтгэврийн даатгал** | - | 10,400,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 67,516,300.00 | 59,324,600.00 |
| **2103** | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 183,191,477.23 | 183,192,100.00 |
| 210301 | **Гэрэл, цахилгаан** | 66,410,190.23 | 74,775,723.00 |
| 210302 | Түлш, халаалт | 91,038,969.00 | 93,061,838.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 25,742,318.00 | 15,354,539.00 |
| **2104** | Хангамж, бараа материалын зардал | 200,961,439.00 | 223,036,100.00 |
| 210401 | **Бичиг хэрэг** | 20,104,000.00 | 19,967,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 154,682,259.00 | 176,892,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,095,180.00 | 22,096,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| **2105** | Нормативт зардал | 57,062,000.00 | 147,181,376.00 |
| 210501 | **Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл** | 200,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 54,365,000.00 | 145,381,376.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,497,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | Эд хогшил, урсгал засварын зардал | 63,368,439.00 | 74,240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 3,993,339.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 59,375,100.00 | 70,240,000.00 |
| **2107** | Томилолт, зочны зардал | 20,094,900.00 | 27,411,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 20,094,900.00 | 27,411,000.00 |
| **2108** | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,361,600.00 | 7,362,000.00 |
| 210801 | **Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж** | 9,999,600.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,505,000.00 | 1,505,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 407,000.00 | 407,000.00 |
| **2109** | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,303,449.00 | 45,993,360.00 |
| 210901 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 22,393,450.00 | 44,286,860.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,909,999.00 | 1,706,500.00 |
| **213** | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 5,818,902.00 | 6,607,263.00 |
| **2132** | Бусад урсгал шилжүүлэг | 4,700,000.00 | 4,340,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 4,200,000.00 | 3,840,000.00 |
| **2133** | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,118,902.00 | 2,267,263.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,118,902.00 | 2,197,263.00 |
| **3** | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 3,090,000.00 | 65,133,500.00 |
| **5** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 3,090,000.00 | 65,133,500.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **3,090,000.00** | **65,133,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **3,090,000.00** | **65,133,500.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 3,090,000.00 | 65,133,500.00 |
| **6** | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | (3,090,000.00) | (65,133,500.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | - | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | 2,722,692,062.39 | 1,644,373,480.72 | 3,041,070,421.70 | - | 7,408,135,964.81 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,722,692,062.39** | **1,644,373,480.72** | **3,041,070,421.70** | - | 7,408,135,964.81 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | (415,330,264.31) | - | (415,330,264.31) |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,722,692,062.39** | **1,644,373,480.72** | **2,625,740,157.39** | - | 6,992,805,700.50 |
| D01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,722,692,062.39** | **1,644,373,480.72** | **2,625,740,157.39** | - | 6,992,805,700.50 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **2,722,692,062.39** | **1,644,373,480.72** | **2,625,740,157.39** | - | 6,992,805,700.50 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (264,616,236.87) | - | (264,616,236.87) |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **2,722,692,062.39** | **1,644,373,480.72** | **2,361,123,920.52** | - | 6,728,189,463.63 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,399,886,600.00 | 3,399,886,600.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,399,886,600.00 | 3,399,886,600.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,395,546,600.00 | 3,395,546,600.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,812,969,400.00 | 2,812,969,400.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,572,633,500.00 | 1,572,633,500.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,208,786,800.00 | 1,208,786,800.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 31549100.00 | 31549100.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,868,500.00 | 66,868,500.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | - | 10,400,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 66,868,500.00 | 56,467,900.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 183,192,100.00 | 183,192,100.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 55,857,900.00 | 74,775,723.00 |
| 210302 | Түлш, халаалт | 101,245,400.00 | 93,061,838.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 26088800.00 | 15354539.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 187,063,600.00 | 187,063,600.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 20,104,000.00 | 20,104,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 140,783,600.00 | 140,783,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 22,096,000.00 | 22,096,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 120,000.00 | 120,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 660,000.00 | 660,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,300,000.00 | 3,300,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 35,000,000.00 | 35,000,000.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 300,000.00 | 300,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 33,200,000.00 | 33,200,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 74,240,000.00 | 74,240,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,000,000.00 | 4,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 70,240,000.00 | 70,240,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 26,351,000.00 | 26,351,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 26,351,000.00 | 26,351,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 7,362,000.00 | 7,362,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,505,000.00 | 1,505,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 407,000.00 | 407,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 4,340,000.00 | 4,340,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 4,340,000.00 | 4,340,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 458,300.00 | 500,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,881,700.00 | 3,840,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,399,886,600.00 | 3,399,886,600.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,319,770,700.00 | 3,317,573,437.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,319,770,700.00 | 3,317,573,437.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 80,115,900.00 | 82,313,163.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 80,115,900.00 | 82,313,163.00 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **291,534,936.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **291,534,936.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **291,464,936.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 30,767,500.00 |
| 210101 | Үндсэн цалин | 30,767,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 2,856,700.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2,856,700.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **36,109,000.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 36,109,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **112,181,376.00** |
| 210502 | Хоол, хүнс | 112,181,376.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 62,500,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 62,500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,060,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,060,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,990,360.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 45,990,360.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **70,000.00** |
| 213305 | Төвлөрүүлэх шилжүүлэг /нэмэлт/ | 70,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **291,534,936.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **291,534,936.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 22,255,376.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 269,279,560.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Ариунаа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн 47/3449 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын эрхэм зорилго нь “Цагдаагийн ажил үйлчилгээг хуулийн хүрээнд чанартай, ил тод, хүртээмжтэй, шуурхай хүргэж, иргэд олон нийтийн амар тайван байдлыг хангасан нутаг дэвсгэрийн загвар цагдаагийн байгууллага болох.” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх Хяналт шалгалт, үнэлгээ дотоод аудитын хэлтсээс 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит гүйцэтгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "бага" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,866.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 57.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 37.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 278.5 сая төгрөгөөр буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /сая төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 81.8 | 72.8 | 9.0 |
| Урьдчилгаа | 04.9 | 04.6 | 0.3 |
| Бараа материал | 353.2 | 325.1 | 28.1 |
| Үндсэн хөрөнгө | 6,625.7 | 6,384.7 | 241.0 |
| **Нийт хөрөнгө** | **7,065.6** | **6,787.2** | 278.5 |
| Өр төлбөр | 72.8 | 59.0 | 13.8 |
| Засгийн газрын оролцоо | 6,992.8 | 6,728.2 | 264.6 |
| Засгийн газрын оролцоо /Өмч-Төрийн/ | 2,722.7 | 2,722.7 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 2,625.7 | 2,625.7 | - |
| Тайлант үеийн үр дүн | 00.0 | -264.6 | 264.6 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,644.4 | 1,644.4 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **7,065.6** | **6,787.2** | **278.5** |

Авлага дансны үлдэгдэл нь хуучин орон сууц борлуулснаас үүссэн авлага ба тайлант онд 9.0 сая төгрөгөөр барагдсан.

Бараа материалын дансны үлдэгдэл 325.1 сая болж 28.1 сая төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,384.7 сая төгрөг болж 241.0 сая төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжиж ирсэн болон худалдан авсан хөрөнгөөр нэмэгджээ.

Өмнөх оны өр 59.0 сая төгрөг болж 13.8 сая төгрөгөөр буурсан нь байгууллагад орон сууц худалдан авахад үүссэн өр бөгөөд тайлант онд 9.0 сая төгрөгийг авлагатай хувь хүмүүсээс авч, 4.8 сая төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос төлсөн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 6,728.2 сая болж 264.6 сая төгрөгөөр буюу тайлант үеийн үр дүнгээр буурсан.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 461.4 сая төгрөгөөр буюу 13.4 хувиар буурсан нь өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 310.7 сая төгрөгөөр буюу 8.0 хувиар өссөн нь өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой байна. Уг зардлууд “Ковид-19” цар тахлын улмаас дээд шатны байгууллагаас санхүүжилт олгож зарцуулсантай холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 3,382.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 17.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж 3,399.9 сая төгрөгөөр баталсан байна

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3,399.9 сая төгрөгийн төсөв батлагдсаныг 3,319.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 80.1 сая төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,319.8 сая төгрөг, үндсэн ажиллагааны орлого 80.1 сая төгрөг, нийт 3,399.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 3,399.9 төгрөгийг зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 22.3 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл

үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 269.3 нийт 291.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, 291.5 төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн аудитын асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.7.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд шилэн дансны нэгдсэн системд байршуулсан мэдээллийг шалгахад 822.9 сая төгрөгийн 39 худалдан авалтыг, 3,598.4 сая төгрөгийн 54 орлогын, 347.0 сая төгрөгийн 39 зарлагын мөнгөн гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

### 3.8 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах 1 зөвлөмж өгөгдсөн нь бүрэн хэрэгжсэн байна.

### 3.9 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар бараа материалын анхан шатны баримт бүрдүүлэлт тэр дундаа шатах тослох материалын олголт, зарцуулалт, тооцоог авч үзэх болно.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 7.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 1 албан шаардлага хүргүүлсэн.

### 4.1. Залруулсан алдаа

Аудитын явцад залруулга хийгдээгүй.

### 4.2. Албан шаардлага

Аудитаар залруулагдаагүй 7.2 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Түлш халаалтын зардлаас засварын материал худалдан авч, батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчсөн байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">д/д</th><th rowspan="3">Аудитад хамрагдсан байгууллагын нэр</th><th colspan="2" rowspan="2">Нийт алдаа, зөрчлийн</th><th colspan="8">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Залруулга</th><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td colspan="12">Санхүүгийн тайлангийн аудитын асуудал</td></tr>
<tr><td>1</td><td>Батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчиж гүйлгээ хийсэн.</td><td>1</td><td>7.2</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>7.2</td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="2">Дүн</td><td>1</td><td>7.2</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>7.2</td><td></td><td></td></tr>
</table>

,

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 08/12370448 ХЭА-2022 Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Түлш халаалтын зардлаас 7,200.0 мянган төгрөгийн засварын материал худалдан авч, батлагдсан төсвийн эдийн засгийн ангиллыг зөрчин зарцуулсан байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д *"төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулдаггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, цагдаагийн хурандаа Д.Батхүү, нягтлан бодогч Ж.Баатар нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Б.АРИУНАА

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
CIOA0040 9874062

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 70562112